



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн зээлээр
гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн Монгол Улсын их сургуулийн багш нарын чадавхийг дээшлүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Монгол улсын их сургуулийн багш Баяржаргалын **Ариун-Эрдэнийг** Австрали Улсын Үндэсний их сургуулийн докторантурт Хөгжлийн эдийн засгийн чиглэлээр 3 жилийн, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн багш Пүрэвдоржийн **Баясгаланг** Тайландын Вант Улсын Махидол их сургуулийн магистрантурт Нүд судлалын чиглэлээр 3 жилийн хугацаатайгаар суралцуулсугай.

2. Суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР